



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 07 сарын 01 өдөр

Дугаар A/55

Улаанбаатар хот

“Шударга ёсны төлөө” уралдаан зохион байгуулах,  
үнэлэх аргачлал батлах тухай

Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.4, 23 дугаар зүйлийн 23.1.6, 23.2-т тус тус заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. “Шударга ёсны төлөө” уралдаан зохион байгуулах, үнэлэх аргачлал”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү аргачлалын дагуу төрийн байгууллага, төрийн өмчит хуулийн этгээд, хувийн хэвшил, иргэн, иргэний нийгмийн байгууллага, албан тушаалтны дунд зохион байгуулах “Шударга ёсны төлөө” сайн засаглалыг төлөвшүүлэх зорилготой сайн туршлага, санаачилга шалгаруулах ажлыг жил бүр тогтоосон хугацаанд зохион байгуулахыг Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Б.Бат-Отгонд үүрэг болгосугай.


3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар З.Баасаннямд даалгасугай.

ДЭД ДАРГА,  
ЭРХЭЛСЭН КОМИССАР

Ц.НЯМДОРЖ


ХУУЛБАР ҮНЭН:

Тамгын хэлтсийн дарга,  
эрхэлсэн комиссар



З.БААСАННЯМ

000618



**“ШУДАРГА ЁСНЫ ТӨЛӨӨ” УРАЛДААН  
ЗОХИОН БАЙГУУЛАХ, ҮНЭЛЭХ АРГАЧЛАЛ**

**Нэг. Оршил**

Авлигатай тэмцэх газраас төрийн үйлчилгээний хүнд суртлыг багасгах, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэх, хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг тусалцаа үзүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газартай хамтран 2008 оноос яам, агентлаг, аймаг, нийслэлийн түвшинд авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ирсэн.

Төлөвлөгөөний хэрэгжилтийн байдал, хүрсэн үр дүн зэргээс шалтгаалан авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг шинэ шатанд хүргэх, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, хяналт тавих боломжийг тэдэнд олгох, шударга ёсыг бэхжүүлэх, хариуцлагыг чангатгах, нийтийн албаны үйл ажиллагааг нийтийн ашиг сонирхолд нийцүүлэх, олон улсын тэргүүн туршлагыг нэвтрүүлэх, хуулиар хүлээсэн үүргээ төгс биелүүлэх замаар **авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх ажлыг** зөвхөн төлөвлөсөн хүрээнд биш байгууллага, салбар, орон нутгийн онцлогт тохирсон илүү өргөн хүрээнд зохион байгуулж ажиллахыг зорьж байна.

Энэхүү ажлын хүрээнд жил бүрийн 12 дугаар сарын 09 /Авлигын эсрэг олон улсын өдөр/-ний өдрийг угтан иргэд, олон нийтийг хамарсан олон талт арга хэмжээг зохион байгуулж ирсний нэг нь сайн засаглалыг төлөвшүүлэх, ил тод байдлыг хангах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг идэвхи санаачилгатай хэрэгжүүлж буй төрийн байгууллага, төрийн өмчит хуулийн этгээд, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллага, түүний төлөөлөл /жил бүр 9 төрлөөр байгууллага, албан тушаалтны сайн туршлага, үйл ажиллагаа, санал санаачилга/-д олгож байхаар тогтсон.

**Хоёр. Зорилго**

- Авлигын эсрэг хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлэх, хэрэгжилтийг хангуулах;
- Албан хаагчдын шударга байдлын түвшинг нэмэгдүүлэх;
- Авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, санал санаачилга, хүчин чармайлтыг дэмжих;
- Төрийн байгууллагаас хэрэгжүүлж буй үлгэр жишээ, тэргүүн туршлагыг илрүүлэх, түгээн дэлгэрүүлэх;
- Төрийн байгууллага хоорондын авлигын эсрэг үйл ажиллагаанд өрсөлдөөнийг бий болгох;
- Олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигын эсрэг үйл ажиллагаанд иргэд олон нийт, иргэний нийгмийн байгууллагыг татан оролцуулах.

**Гурав. Ач холбогдол**

- Авлигын эсрэг хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлнэ;
- Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангана;
- Байгууллага хоорондын авлигын эсрэг үйл ажиллагаан дахь санал, санаачилгыг нэмэгдүүлнэ;

- Төрийн байгууллагын үйл ажиллагаанд тавих иргэний хяналт сайжирна;
- Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үр дүнд ахиц дэвшил гарна.

### **Дөрөв. Эрх зүйн үндэслэл**

Авлигын эсрэг хууль:

- 18 дугаар зүйл. 18.1.1. Улсын хэмжээнд авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах, нэгдсэн хөтөлбөр боловсруулах, арга зүйн удирдлагаар хангах, хэрэгжилтэд нь хяналт тавих;
- 18 дугаар зүйл. 18.1 4. Төрийн бус байгууллага, иргэдээс авлигатай тэмцэх талаар явуулж байгаа үйл ажиллагаа, гаргасан санал, санаачилгыг дэмжин туслах, тэдний оролцоог нэмэгдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг авах;

### **Тав. Баримтлах зарчим**

5.1. Уралдааныг дүгнэхэд дараахь зарчмыг баримтална:

- Шударга байх;
- Тэгш байдлыг хангасан байх;
- Ил тод, нээлттэй байх;
- Хөндлөнгийн хараат бус байх;
- Олон нийтийн оролцоонд тулгуурласан байх.

### **Зургаа. Оролцоо**

6.1. Авлигатай тэмцэх газар */зохион байгуулах байгууллага/,* АТГ-ын даргаас баталсан ажлын хэсэг */шалгаруулах ажлын хэсэг/,* төрийн байгууллага, төрийн өмчит хуулийн этгээд, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагууд */оролцогч/* гэсэн оролцоотой байх ба дараах чиг үүргийг гүйцэтгэнэ:

а/ Авлигатай тэмцэх газар:

- Шударга ёсны төлөө уралдааны шалгуур үзүүлэлт, үнэлэх аргачлалыг боловсруулан батлуулах;
- Уралдааны удирдамж хүргэх, сурталчлах;
- Уралдааны материалуудыг хүлээн авах, бүртгэх, ажлын хэсэгт хүлээлгэн өгөх;
- Уралдаан шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг тушаалаар батлуулах;
- Ажлын хэсгийн шалгаруулалтын байр бэлтгэх, уралдаанд ирүүлсэн материал, бүртгэл, үнэлгээний хуудас зэргийг хүлээлгэн өгөх;
- Шаардлагатай мэдээллийг ажлын хэсэгт гаргаж өгөх бөгөөд тус шалгаруулах үйл ажиллагаанд дэмжлэг, туслалцаа үзүүлэх;
- Шалгаруулалтын дүнг газрын даргын зөвлөлөөр хэлэлцэн баталгаажуулах;
- Шалгарсан байгууллага, албан тушаалтан, иргэнд мэдэгдэх, шагнал гардуулах ажлыг зохион байгуулах;
- Шалгарсан сайн туршлагыг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх;

б/ Оролцогч байгууллагууд :

- Уралдааны удирдамжид заагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу тайлан, холбогдох мэдээллийг заасан хугацааны дотор Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх;



- Шаардлагатай нотлох баримтыг хавсарган ирүүлэх;
- Мэдээллээ цахим хуудас, мэдээллийн самбартаа тогтмол байршуулсан бол эх үүсвэрийн талаар тодорхой тайлбарлах;
- Шалгуур үзүүлэлт, хугацаа, ирүүлэх материал зэрэг уралдаантай холбоотой асуудлаар Авлигатай тэмцэх газраас мэдээлэл, арга зүйн зөвлөгөө авах;

в/ Уралдааныг шалгаруулах ажлын хэсэг:

- Уралдааныг шалгаруулах ажлыг зохион байгуулах
- Уралдааны шалгаруулалт болон явц байдлын талаарх тэмдэглэл үйлдэх, шалгаруулалтын дүнг газрын даргын зөвлөлд танилцуулах, шаардлагатай материалыг архивын нэгж болгон өгнө.

### Долоо. Үнэлгээний агуулга, арга зүй

7.1 “Шударга ёсны төлөө” уралдааны шалгуур үзүүлэлтийн дагуу номинаци тус бүрийн онцлогоос хамааран 100 хүртлэх оноогоор дүгнэн, хамгийн өндөр оноотойг шалгаруулна.

7.2 Шалгаруулах ажлын хэсэг тухайн номинаци тус бүрт тусгагдсан шалгуур үзүүлэлтийн хүрээнд оролцогч байгууллагуудаас ирүүлсэн тайлан мэдээлэл болон авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг үнэлэхдээ төрийн байгууллага, төрийн өмчит хуулийн этгээд, тэдгээрийн албан тушаалтнуудын хувьд тухайн жилд хийхээр төлөвлөсөн ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн тайланд үндэслэхийн зэрэгцээ нотлох баримт /цахим хуудас, хавсарган ирүүлсэн материал/-д шинжилгээ хийж үнэлгээ өгнө.

7.3 Хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын хувьд ирүүлсэн тайлан, нотлох баримт, эх үүсвэрийн тайлбар зэргийг үндэслэн шинжилгээ хийж үнэлгээ өгнө.

### Найм. Шалгуур үзүүлэлт

8.1 “Шударга ёсны төлөө” уралдааны шалгуур үзүүлэлтэд тухайн жилийн онцлогоос хамааран номинацийн төрөлд өөрчлөлт орох тохиолдолд уралдааны удирдамжид тусган албажуулна.

| Дэд хэсэг | Номинацийн төрөл  | Номинаци  |          | Тайлбар |
|-----------|---|---|----------|---------|
|           |   | Шалгуур   |          |         |
|           |   | Гүйцэтгэлийн үзүүлэлт   | Оноо 100 |         |
| 1         | <b>Авлига, ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх хүсэл эрмэлзэлтэй удирдлага</b><br><br><b>Зорилго:</b><br><br>Олон нийт тэр дундаа төрийн байгууллагын удирдах ажилтны авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэлийг | 1.1 Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг үнэлэх аргачлалын Авлигатай тэмцэх санал санаачилгын шалгуур үзүүлэлтээр 25-аас дээш оноогоор үнэлэгдсэн байх | 30       |         |
|           |   | 1.2. Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр шинэлэг ажил, үр дүнтэй арга хэмжээ санаачлан хэрэгжүүлсэн байх   | 30       |         |

|   |   |   |                      |   |
|---|---|---|----------------------|---|
|   | нэмэгдүүлэх, уриалах, үлгэр дууриалал үзүүлэх   | 1.3. Хөндлөнгийн үнэлгээ хийх боломжийг бүрдүүлсэн төрийн болон төрийн өмчит хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан байх   | 20                   |   |
|   |   | 1.4. Удирдах албан тушаалтан нь шударга, хариуцлагатай байх чиглэлээр судалгаа шинжилгээ хийн үр дүнг тооцох, ажилтнуудад нөлөөлөх чиглэлээр бодитой ажил хэрэгжүүлсэн байх   | 20                   | Байгууллага, салбарын албан хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлэх судалгааны дүнг дээшлүүлэх чиглэлээр хийгдсэн ажлууд орно.   |
| 2 | <b>Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр олон нийтэд хүртээмжтэй, оролцоог хангасан болон байгууллагын алба хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлэх аян, арга хэмжээ зохион байгуулсан байгууллага</b><br><b>Зорилго:</b><br>Иргэд, олон нийтийн авлига, ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх хүсэл эрмэлзлэлийг нэмэгдүүлэх, уриалах, үлгэр дууриалал үзүүлэх | 2.1. Авлигын эсрэг компанит ажил зохион байгуулах арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлсэн байх<br>2.2. Энэхүү ажилд тусгайлан хөрөнгө төсөвлөн зарцуулсан байх<br>2.3. Төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагатай хамтран аян, арга хэмжээ зохион байгуулсан /аяны уриа, уриалга, мэдэгдэл, амлалтыг олон нийтэд сургалт сурталчилгаа, мэдээлэл хийсэн байх<br>2.4. Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр тусгайлан удирдамж, төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлсэн, үр дүнд хүрсэн ажлууд зохион байгуулсан байх | 30<br>20<br>30<br>20 | <br><br>Аян, арга хэмжээний зорилго, хүртээмж, хүрсэн үр дүнг харгалзан үнэлгээг өгнө.<br><br>Өмнөх онуудад уг номинациар шалгарч байсан бол шинээр нэмж хийгдсэн ажлууд байгаа эсэхийг харгалзан үзнэ. |

|   |  |   |    |   |
|---|--|---|----|---|
| 3 | <p><b>Ил тод, нээлттэй цахим байгууллага</b></p> <p><b>Зорилго:</b><br/>         Авлигаас урьдчилан сэргийлэх нэг гол үйл ажиллагаа бол мэдээллийн ил тод байдлыг хангах явдал байдаг. Төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн хувьд мэдээллээ ил тод болгох нэг хэлбэр нь байгууллагын цахим хуудас тул хуулийн хэрэгжилтийг хангах жишиг бий болгох, бусад байгууллагад үлгэр дууриал, туршлага болгох.</p> | 3.1. Мэдээллийн ил тод мэдээлэл авах эрхийн тухай хууль, Шилэн дансны тухай хуулиудын хэрэгжилтийг хангах чиглэлээр санаачилгатай ажилласан байх            | 30 | АУСҮА үнэлэх аргачлалын дагуу шинжээчдийн цахим хуудас үнэлсэн үнэлгээнд тулгуурлах |
|   |  | 3.2. Мэдээлэл технологийн чиглэлээр тогтсон стандарт хангасан гэж дүгнэгдсэн байх   | 30 | Ажилтнуудын цахим хуудсыг үнэлдэг сартутмын үнэлгээг харгалзан үзэх                 |
|   |  | 3.3 Мэдээллийн баазыг тогтмол хуулийн хугацаанд шинэчлэн, иргэдэд мэдээллийг ойлгомжтой, энгийн байдлаар хүргэх /хэлбэр, агуулга/                           | 20 | Хандагчийн тоог харгалзан үзэх  |
|   |  | 3.4. Иргэдэд төрийн үйлчилгээний талаар мэдээлэл хүргэхдээ шинэ арга хэлбэрийг ашигласан, мэдээллийг хялбар хурдан олж авах боломжийг бүрдүүлсэн            | 20 |   |
| 4 | <p><b>Төрийн үйлчилгээг иргэдэд хүнд сурталгүй, түргэн шуурхай хүргэх талаар шинэ санал, санаачилга гаргасан төрийн байгууллага байгууллага</b></p> <p><b>Зорилго:</b><br/>         Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх замаар авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шалгарсан үйл ажиллагааг улсын хэмжээнд тэргүүн туршлага болгон нэвтрүүлэх.</p>   | 4.1. Төрийн үйлчилгээг иргэдэд хүнд суртал, чирэгдэлгүй хүргэх талаар үйл ажиллагааны шинэ санал санаачилга нэвтрүүлэхээр төлөвлөсөн байх                   | 30 |   |
|   |  | 4.2 Дэвшилтэд техник технологи нэвтрүүлсэн, удирдлага, зохион байгууллалтын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн нь бодитой үр дүнг үзүүлсэн байх                   | 30 |   |
|   |  | 4.3. Дэвшилтэд техник технологи нэвтрүүлсэн, удирдлага зохион байгуулалтын үйл ажиллагаанд мониторинг хийж засаж сайжруулах талаар санал санаачилгатай ажил | 20 |   |



|   |  |   |    |  |
|---|--|---|----|--|
|   |  | төлөвлөсөн, хэрэгжүүлсэн байх   |    |  |
|   |  | 4.4 Бусад чиг үүргийн хувьд ижил төстэй байгууллагад үйл ажиллагааг цаашид сайн туршлага болгон ашиглах боломжтой байх  | 20 |  |
| 5 | <p><b>Идэвхи, санаачилгатай Эрх бүхий албан тушаалтан</b></p> <p><b>Зорилго:</b><br/>Байгууллагын авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, ХАСХОМ-ийн бүртгэх, хянах, хадгалах чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагааны үр дүнг сайжруулах, хэвшүүлэх, энэ чиглэлээр бусад эрх бүхий албан тушаалтнуудад үлгэр дууриалал болох.</p> | 5.1 Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр албан хаагчдаа авлигын эрсдэлээс хамгаалах бодитой ажлуудыг төлөвлөн хэрэгжүүлсэн байх   | 30 |  |
|   |  | 5.2 АУСҮА-ны төлөвлөгөө, түүний биелэлт, ХАСХОМ хүлээн авах, бүртгэх, тайлагнах зэрэг тайлан мэдээг хууль тогтоомжид заасан хугацаанд гарган ирүүлсэн байх  | 20 | АТГ-ын даргын 2016 оны А/54 тоот тушаалаар батлагдсан “Эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааг үнэлэх шалгуур үзүүлэлт” үнэлгээг харгалзан үзэх |
|   |  | 5.3 Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах сургалт сурталчилгаа, гарын авлагаар хангах, арга зүйн туслалцаа үзүүлэх зорилгоор гарын авлага, тараах материал өөрөө санаачлан боловсруулсан, хэвлүүлсэн, түгээсэн, үйл ажиллагаандаа ашигласан байх | 20 |  |
|   |  | 5.4 АТГ-аас зохион байгуулж буй үйл ажиллагаанд идэвхи санаачилгатай оролцдог, бодитой үйл ажиллагаа хэрэгжүүлсэн байх  | 15 |  |
|   |  | 5.5 Тухайн хэрэгжүүлсэн үйл ажиллагаатай холбоотой өргөдөл гомдол шалгагдаж, зөрчил тогтоогдоогүй байх  | 15 |  |

|   |   |  |    |  |
|---|---|--|----|--|
| 6 | <p><b>Хүүхэд залууст шударга ёсыг ойлгуулах, түгээн дэлгэрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан төрийн байгууллага, ТББ, хэвлэл мэдээллийн байгууллага</b></p> <p><b>Зорилго:</b><br/>Шударга нийгмийг цогцлоон бүрдүүлэхэд хүүхэд залуучуудад авлигын эсрэг үзэл санааг таниулах, ухуулах, сурталчлах;</p>                            | 6.1 АТГ-аас хүүхэд залуучуудад зориулан боловсруулан болон эмхэтгэн гаргасан гарын авлага материалыг ашиглан зорилтот бүлэгт чиглэсэн сурталчлан таниулах нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулсан | 30 |  |
|   |   | 6.2 Хүүхдийн шударга байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр өөрийн санал, санаачилга гаргаж ажилласан   | 30 |  |
|   |   | 6.3 Сургалтын байгууллагууд хүүхдэд шударга ёс, зөв зан үйлийг сурталчлах чиглэлээр сургалтын шинэлэг арга хэлбэр нэвтрүүлсэн, сургалтын гарын авлага материал /хэвлэмэл, видео, аудио/ бэлтгэн хүргэсэн | 20 |  |
|   |   | 6.4 Хэвлэл мэдээллийн болон мэргэжлийн урлагийн байгууллага нийтлэл, нэвтрүүлэг, үйл ажиллагааныхаа бодлогыг чиглүүлэн ажилласан байх  | 20 |  |
| 7 | <p><b>Шударга ёс бидний тэмүүлэл” хичээлийн хөтөлбөрийг хүүхэд залууст сонирхолтой хэлбэрээр баяжуулан таниулах ажлыг зохион байгуулсан сургалтын байгууллага</b></p> <p><b>Зорилго:</b><br/>Шударга нийгмийг цогцлоон бүрдүүлэхэд хүүхэд залуучуудад авлигын эсрэг үзэл санааг таниулах, ухуулах, шударга зан үйлийг төлөвшүүлэх</p> | 7.1 Шударга ёс бидний тэмүүлэл” хичээлийн хөтөлбөрийн гарын авлагын агуулгыг баяжуулан сурагчдад мэдлэг, мэдээлэл өгөх ажлыг төлөвлөсөн байх   | 30 |  |
|   |   | 7.2 Хичээл бусад арга хэлбэрээр сурталчлан таниулах шинэ хөтөлбөр боловсруулан хүргэсэн, үр дүнг тооцсон байх  | 30 |  |
|   |   | 7.3 Сургалт, арга хэмжээнд хамрагдсан сурагчдын болон зохион байгуулсан арга хэмжээний талаарх дэлгэрэнгүй тайлан ирүүлсэн байх  | 20 |  |
|   |   | 7.4 Хүүхдийн шударга байдлыг нэмэгдүүлэх, төлөвшүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулах, хүргэх чиглэлээр багш   | 20 |  |



|   |  |   |    |   |
|---|--|---|----|---|
|   |  | нарын дунд компанит ажил зохион байгуулсан байх   |    |   |
| 8 | <p><b>Салбарын шударга байдлыг дэмжих аянд идэвхитэй оролцсон хамт олон, байгууллага</b></p> <p><b>Зорилго:</b><br/>Иргэдэд үзүүлж үйлчилгээг иргэд олон нийтэд ил тод нээлттэй болгох, авлига, ашиг сонирхлын зөрчил, хүнд суртал гарахаас урьдчилан сэргийлсэн тодорхой үр дүн бүхий ажлыг санаачлаж ажилласан бусад салбарын байгууллагуудад хэрэгжүүлж болох сайн санаачилга, тэргүүн туршлага илрүүлэх /боловсрол, уул уурхай, барилгын салбарт тусгайлан авч хэрэгжүүлсэн аян/</p> | 8.1 Авлигын эсрэг хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргээ идэвхи санаачилгатай хэрэгжүүлсэн байх  | 30 | Шинжээчдийн үнэлгээгээр багцын дунджаас дээгүүр үнэлгээтэй байх   |
|   |  | 8.2 Иргэдэд үйлчилгээ /үзүүлж буй төлбөрт үйлчилгээний жагсаалтыг мэдээллийн самбар болон кассын дэргэд энгийн ойлгомжтой байдлаар байршуулах   | 30 |   |
|   |  | 8.3 Байгууллагын ажилтны бэлэн мөнгөтэй шууд харьцахгүй байх нөхцлийг бүрдүүлэх, үйлчилгээ үзүүлэх болон үзүүлсэн талаарх мэдээлэл/-г иргэд олон нийтэд ил тод нээлттэй болгосон байх                       | 20 |   |
|   |  | 8.4 Салбарын болон байгууллагын ёс зүйн дүрмийг сурталчлах, таниулах, мөрдүүлэх, үр дүнг тооцох ажлыг шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулсан байх   | 20 |   |
| 9 | <p><b>Сайн засаглалыг төлөвшүүлэх, ил тод байдлыг хангах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд идэвхи санаачилгатай оролцож буй иргэн, төрийн бус байгууллага</b></p> <p><b>Зорилго</b><br/>Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, сурталчлах энэ үйл</p>  | 9.1 Сайн засаглал, ил тод байдлыг хангах чиглэлээр санал санаачлага гарган хэрэгжүүлсэн байх  | 30 | Авлигын эсрэг үйл ажиллагаанд өөрийн идэвхи санаачилгатай үйл хэрэг, үйл ажиллагаагаар бодитой хувь нэмэр оруулсан болон оруулж буй |
|   |  | 9.2 Уг үйл ажиллагаа нь төрийн байгууллага, төрийн өмчит байгууллагуудын үйл ажиллагаанд ашиглаж болохуйц /судалгаа, шинжилгээ, гарын авлага материал, сургалтын хэрэглэгдэхүүн гэх мэт/ үр дүн гарсан байх | 30 |   |

|  |  |   |    |                               |
|--|--|---|----|-------------------------------|
|  | ажиллагаанд иргэдийн татан оруулцуулах, идэвхи чармайлт, санаачилгыг нэмэгдүүлэх | 9.3 АТГ-ын болон иргэний нийгмийн байгууллагуудын өгсөн зөвлөмжийн биелэлтийг хөндлөнгийн хяналтын чиглэлээр мониторинг хийсэн байх /орон нутаг, нийслэл/   | 20 | иргэн, төрийн бус байгууллага |
|  |  | 9.4 Авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаарх ойлголт, нийгмийн хор аюулыг ухуулан таниулах чиглэлээр ном гарын авлага боловсруулан түгээсэн, олон нийтийг хамарсан компани ажил зохион байгуулсан байх | 20 |                               |

**Ес. Уралдааны хугацаа, үр дүнг мэдээлэх**

9.1 Зохион байгуулагч байгууллага нь жил бүрийн нэгдүгээр улиралд уралдааны удирдамжийг нийтэд хүргэх ажлыг зохион байгуулна.

9.2 Оролцогч байгууллагууд нь “Шударга ёсны төлөө” уралдаанд оролцох номинацийн шалгуур үзүүлэлт хангасан үйл ажиллагааны болон албан тушаалтны талаарх тайлан, холбогдох материалын хамт Авлигатай тэмцэх газарт тухайн оны 11 дүгээр сарын 25-ны дотор ирүүлнэ.

9.3 Шалгаруулах ажлын хэсгээс өгсөн үнэлгээний дүнг жил бүрийн 12 дугаар сарын 9 буюу “Авлигын эсрэг” олон улсын өдрийг угтсан арга хэмжээний хүрээнд олон нийтэд мэдээлэх ба шагнал гардуулах ажлыг зохион байгуулна.

--oOo--